



**МОНГОЛЫН ХӨЛБӨМБӨГИЙН ХОЛБООНЫ
ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР**

**ФУТЗАЛЫН
НЭГДҮГЭЭР ЛИГ
2024-2025**



2024 оны 12-Р САРЫН 9

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Монгол улсад Футзалын спортыг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх зорилтын хүрээнд МХБХ-ны "Футзалын Нэгдүгээр Лиг" /цаашид Лиг гэх/-ийг, Монголын Хөлбөмбөгийн Холбоо /цаашид МХБХ гэх/ бодлогын хүрээнд зохион байгуулахад оршино.
- 1.2. Футзалын клубүүдийн үйл ажиллагааг мэргэжлийн төвшинд бэлтгэх.

Хоёр. Лигийн зохион байгуулалт

- 2.1.1 МХБХ-ны Тэмцээн зохион байгуулах хэлтэс /цаашид "ТЗБХ" гэх/ нь, Олон Улсын Хөлбөмбөгийн холбоо /цаашид "ОУХБХ" гэх/, Азийн хөлбөмбөгийн холбоо /цаашид "АХБХ"/, Монголын хөлбөмбөгийн холбоо /МХБХ/-ны дүрэм, журмуудыг болон бусад эрх зүйн баримт бичгүүдийг үндэслэн зохион байгуулна.
- 2.1.2 МХБХ-ны эрх зүйн баримт бичгүүдэд тусгагдаагүй аливаа асуудлуудыг ОУХБХ болон АХБХ-ны эрх зүйн баримт бичгүүдийг мөрдөнө.
- 2.1.3 Лиг нь 2024/12/20 – 2025/06/15 хүртэл зохион байгуулагдана.
- 2.1.4 Лиг нь 10 багийн нэг тойргийн системээр тойргийн тоглолтууд хийж тойргийн төгсгөлд хүснэгтийн 1-8 бичигдэж буй багууд хоёр хуваагдаж нэг тойргийн тоглолтууд хийнэ.
Лигийн шилдэг тоглогчид зөвхөн дээд шатлалаас сонгогдоно.
- 2.1.5 **Мэдүүлэг авах эцсийн хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 16-ний 17:00 цаг хүртэл**

- 2.1.6 Футзалын Нэгдүгээр лигт 10 баг өрсөлдөх эрхтэй.

ФУТЗАЛЫН НЭГДҮГЭЭР ЛИГ 2024-2025
ХАРААЦАЙ
ХҮСЛИЙН ГООЛ
ШОНХОР
ШОНХОРУУД
ШИНЭ НАЛАЙХ
СОР
ХОВД ВЕСТЕРН
БАВАРИАНС
СОНИРХОГЧДЫН ЦОМ #1
СОНИРХОГЧДЫН ЦОМ #2

- 2.1.7 Лигийн бүх үйл ажиллагаа МХБХ-ны “Тэмцээн зохион байгуулах журам”-ын дагуу явагдана.
- 2.1.8 Лигт оролцох клуб, багийг төлөөлж зөвхөн 1 баг оролцоно.
- 2.1.9 Тоглолт 2 үеэр тус бүр 20 минут цэвэр цагаар, дундаа 10 минутын завсарлагатай үргэлжилнэ.
- 2.1.10 Багийн бүрэлдэхүүнд нийт 20 тоглогч бүртгүүлэх боломжтой ба 4 албаны хүн байна. Үүнд: Ахлах дасгалжуулагч, туслах дасгалжуулагч, багийн менежер болон багийн эмч заавал байна.
- 2.1.11 Тоглолт бүрийн өмнө багийн бүрэлдэхүүнээс 14 тоглогчийг сонгож тухайн тоглолтод оролцоно.
- 2.1.12 Лигт оролцох багуудын эрхийн төлбөр **500,000₮** байна. Төлбөрийг МХБХ-ны Санхүүгийн хэлтэст тушаана.

Голомт Банк : 3015101105 Монголын Хөлбөмбөгийн Холбоо

- 2.1.13 Лигт зөвхөн мэдүүлэгт тусгагдсан дасгалжуулагч, тоглогч нар оролцоно. Багийн мэдүүлэгт багтсан хүн нь зөвхөн 1 (нэг) статустай байна.
- 2.1.14 МХБХ-ноос зохион байгуулсан Лигийн тоглолт бүрд шүүгчийн шийдвэр эцсийнх байна.

- 2.1.15 МХБХ-ны Лигийн үеэр ТЗБХ-т хандсан хүсэлт гомдлыг зөвхөн бичгээр хүлээн авна. Тоглолтын шүүлттэй холбоотой аливаа гомдлыг хүлээж авахгүй.
- 2.1.16 Лигийн тоглолтын үеэр сахилга батын асуудал гарсан тохиолдолд ТЗБЖ-ын дагуу бичлэг үзэж нөхөж шийдвэрлэх боломжтой.
- 2.1.17 Багууд тоглолт эхлэхээс 60 минутын өмнө талбайд ирсэн байх шаардлагатай. Тоглолтын протоколыг тоглолт эхлэхээс 40 минутын өмнө ТЗБХ-ээс томилогдсон тоглолт зохион байгуулагчид хүлээлгэж өгнө. Мөн энэ үеэр багийн тоглогч нарын хувцас хэрэглэлийн шалгалтыг хийнэ. Протоколыг тоглолт зохион байгуулагч болон багийн ахлах дасгалжуулагч гарын үсэг зурснаар хүчинтэйд тооцож хэвлэл мэдээлэл болон шаардлагатай бүх сүлжээнд тараагдана. Тоглолт эхэлсний дараа нэмэгдэж ирсэн тоглогчийг тоглолтод оролцуулахгүй.
- 2.1.18 Тоглолтын протоколыг тогтоосон хугацаанд бөглөж ирүүлээгүй улмаас тоглолт эхлэх хугацааг хойшлуулсан тохиолдолд багт сахилгын арга хэмжээ авна.
- 2.1.19 Лигийн нэг тоглолтод нэг багийн 5 тоглогч шар хуудсаар торгуулсан тохиолдолд тухайн багийг 100,000₮ тorgох болно. Тухайн тоглолтод 6-7...-x дараалсан шар хуудас авсан тоглогч тус бүрийг 20,000₮ тorgоно. Шууд улаан хуудсаар торгуулсан тоглогчийг 50,000₮ тorgоно. Торгуулийг дараагийн тоглолтын өмнө МХБХ-ны Санхүүгийн хэлтэст тушаасан байна. Торгуулийг хугацаандаа төлөөгүй тохиолдолд торгуулийн дүн тоглолт болгоны тоогоор 2 дахин нэмэгдэх болно.
- 2.1.20 Хуудасны болон сахилгын өнжих шийтгэлүүд нь МХБХ-ны футзалын бүх тэмцээнд хүчинтэй үйлчилнэ.
- 2.1.21 Тоглолт наймаалцах, Лигийн явцад ямар нэгэн байдлаар өөрийн багтаа ашигтайгаар нөлөөлөх үйлдэл хийх, бусад багуудын эрх ашигт ноцтойгоор халдаж Лигийн зохион байгуулалтад хүндрэл учруулсан нь нотлогдвол МХБХ-ны “Сахилгын дүрэм”, “Ёс зүйн дүрэм”-ийн дагуу тус тус хариуцлага хүлээлгэнэ.

Гурав. Багийн албаны хүний үүрэг ба хариуцлага

- 3.1.1 Багийн менежер, ахлах болон туслах дасгалжуулагч, ахлагч, эмч нар нь хариуцсан чиглэлээ төлөөлөх бүрэн чадвартай байж эрх, үүргээ ухамсарласан байна.
- 3.1.2 Багийн менежер нь тухайн багийн мэдээлэл МХБХ-ноос өгч зуй мэдээллийг багтаа дамжуулах, багаа төлөөлөх эрх бүхий албан тушаалтан байна.
- 3.1.3 Багийн ахлах дасгалжуулагч нь **АХБХ-ны футзалын 1-р** зэрэглэлтэй харин туслах дасгалжуулагч нь **МХБХ-ны футзалын 1-р** зэрэглэлтэй байна. Хэрвээ гадаад иргэншилтэй дасгалжуулагч бүртгүүлэх тохиолдолд дээр дурьдсан зэрэглэлтэй адил байх шаардлагатай. Дасгалжуулагчийн бүртгэлийг ТЗБХ-д мэдүүлж, дасгалжуулагчийн лицензийг Техникийн хэлтэст шалгуулна.
- 3.1.4 МХБХ-нд бүртгэлтэй клуб, багийн албаны хүн болон тоглогч нь тоглолтын шүүгчийн шийдвэртэй холбоотой аливаа эсэргүүцлийг сонин хэвлэл, телевиз болон цахим орчин ашиглаж олон нийтэд цацахыг хориглох ба зөрчсөн тохиолдолд МХБХ-ны “Сахилгын дүрэм”-ийн дагуу арга хэмжээ авна.
- 3.1.5 Лигт оролцох дасгалжуулагч нь зөвхөн МХБХ-ны Техникийн хэлтсээс олгосон хүчин төгөлдөр “Дасгалжуулагчийн лиценз”-тэй байж тоглолтонд оролцено. Лицензтэй дасгалжуулагч байхгүй тохиолдолд тоглолт эхлэхгүй. Тоглолтыг цуцлаж эсрэг багт 5-0 гэсэн үр дүнгээр хожлыг эсрэг багт олгоно.
- 3.1.6 Техникийн бүсээс чөлөөлөгдсөний дараа дасгалжуулагч нь үзэгчийн суудлаас тоглолттой холбогдолтой аливаа төрлийн эсэргүүцэл (хэл ам, үйлдэл) болон бусдыг турхирсан үйлдэл гаргасан тохиолдолд тухайн албаны хүнийг МХБХ-ны “Сахилгын дүрэм”-ийн дагуу торгоно.
- 3.1.7 МХБХ-нд бүртгэлтэй клуб, багийн албаны хүн болон тоглогч нь үзэгчдийн суудлаас тоглолттой холбогдолтой аливаа төрлийн эсэргүүцэл (хэл ам, үйлдэл) болон бусдыг турхирсан үйлдэл гаргасан тохиолдолд түүнийг МХБХ-ны “Сахилгын дүрэм”-ийн дагуу торгоно.
- 3.1.8 Хэрэв тоглолтын явцад аливаа шалтгаанаар дасгалжуулагчгүй (багийн менежер, эмчид хамаarahгүй) болсон тохиолдолд тухайн баг нь **“Завсарлага”** авах эрхгүй тоглолтыг дуусгана.
- 3.1.9 Дасгалжуулагч нь клубтэй хийсэн гэрээгээ ТЗБХ-т заавал бүртгүүлнэ.

3.1.10 Лигийн мэдүүлэгт мэдүүлсэн дасгалжуулагчдыг зөвхөн Техникийн хэлтсийн зөвшөөрлөөр Лигт оролцуулна.

Дөрөв. Бүртгэл, шилжилт хөдөлгөөн

- 4.1.1 Лигт оролцож байгаа багууд бүх гэрээтэй тоглогчдоо **FIFA CONNECT** системд заавал бүртгүүлнэ. Бүртгэлд ороогүй тоглогчдыг тоглолтод оролцуулахгүй.
- 4.1.2 Лигт оролцох Гадаад тоглогчийн тоо ТЗБЖ-ын дагуу байна.
- 4.1.3 Албан ёсны мэдүүлгийн анкет болон бусад шаардлагатай хавсралт материалуудыг зөвхөн **.xlsx** (excel sheet) форматаар явуулсан тохиолдолд хүчинтэйд тооцно. Өөр цахим хаяг болон олон нийтийн сүлжээгээр явуулсан мэдүүлгийг хүлээж авахгүй.
- 4.1.4 Дээрх хугацаанаас хоцорсон мөн зохих шаардлагын дагуу явуулаагүй мэдүүлгийг авч хэлэлцэхгүй.
- 4.2 Үүнд:
- ОУХБХ-ны "Шилжилт хөдөлгөөний журам"-ын дагуу өөрийн улсын Хөл Бөмбөгийн Холбооноос Монгол улсын клубт тоглож болно гэсэн албан ёсны зөвшөөрөл,
 - Монгол улсын Иргэний харьялал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газраас тухайн тоглогч нь Монгол улсад хуулийн дагуу ажиллаж амьдрах зөвшөөрлийн бичиг,
 - Паспортын хуулбар,
 - Тухайн тоглогчийг тоглуулах клубын албан ёсны хүсэлт ба Монгол улсад байрлах албан ёсны хаяг,
 - Гэрээний нотариатаар баталгаажуулсан хуулбар,
 - FIFA Connect бүртгэл
- 4.2.1 Монгол улсын иргэн мэдүүлэгт бүртгүүлэхдээ дараах материалуудыг бүрдүүлнэ. Үүнд:
- Тоглогч тухайн клуб, багтай байгуулсан гэрээ,
- 4.2.2 Багийн мэдүүлгийг МХБХ-ны Лигийн зааварт заасан хугацаанд, шаардлагын хэмжээнд бүрэн бүрдүүлж, өгнө.
- 4.2.3 Клуб, багууд тухайн Лигт оролцох үндсэн ба туслах хувцасны өнгийг ТЗБЖ-ын Хавсралт З-аар ирүүлнэ.

- 4.2.4 Тоглогчдын эрүүл мэндийн үзлэгт хамруулсан албан бичгийг мэдүүлэгтэй хамт ТЗБЖ Хавсралт 2-ыг хавсаргаж ирүүлнэ.
- 4.2.5 Дараах шаардлагуудыг хангаагүй мэдүүлгийг бүртгэж авахгүй. Үүнд:
- a) Зураг /сүүлийн 6 сард авахуулсан/ дутуу болон шаардлага хангаагүй,
 - b) Мэдүүлэг баталгаат гарын үсэггүй,
 - c) Багийн менежерийн утасны дугаар болон цахим хаяггүй,
 - d) Хувийн дугааргүй, /1 дугаарыг зөвхөн хаалгач өмсөнө, 0 дугаартай тоглогч байх боломжгүй/
 - e) Регистрийн дугааргүй,
 - f) Овог, нэр дутуу,
 - g) ТЗБЖ-ын Хавсралт 3 бүрдүүлээгүй.
- 4.2.6 Клуб, багууд Лигийн мэдүүлгийг үнэн зөв бөглөж зөрчил гарсан тохиолдолд тухайн клуб, баг бүрэн хариуцна. Клуб, багууд Лигт оролцох эрхгүй тоглогчийг тоглолтод оруулсан тохиолдолд тухайн клуб, багийг Лигээс хасч өмнөх тоглолтуудын оноо, бөмбөгний тоог хүчингүйд тооцно. Мөнгөн торгуулийг давхар ногдуулна.
- 4.2.7 Тоглогчдын бүртгэл, шилжилт хөдөлгөөнтэй холбогдолтой бусад асуудлуудыг МХБХ-ны зохих жүрмын дагуу явагдана. Аливаа шилжилт хөдөлгөөнийг зөвхөн "МХБХ-ны Тоглогчдын статус ба шилжилт хөдөлгөөний журам"-ын дагуу үйлдсэн тохиолдолд хүчинтэйд тооцно.

Тав. Техникийн зөвлөгөөн ба Лигийн сугалаа

- 5.1.1 Тэмцээний зөвлөгөөн 12 дугаар сарын 18-нд 18:00 цагаас зохион байгуулагдана.
- 5.1.2 Тэмцээний зөвлөгөөнд клуб, багийн менежер заавал оролцох шаардлагатай. Лигтэй холбогдолтой бүх мэдээллийг тус зөвлөгөөнд ТЗБХ-ээс өгөх тул дараа нь Лигийн үеэр Лиг зохион байгуулалттай холбоотой асуудал гарвал хүлээж авахгүй.
- 5.1.3 Тэмцээний зөвлөгөөнд клубүүд тоглогчдын болон хаалгачийн 2 ээлжийн хувцсыг заавал авчирна. Багууд эзэн баг болон зочин багийн өмсгөлүүдээ эцэслэн шийдвэрлэсэн байна. Багуудын хувцас хэрэглэлтэй холбогдолтой бүх асуудлуудыг МХБХ-ны "Тоглогчдын хувцас хэрэглэлийн журам"-ын дагуу ТЗБХ шийдвэрлэнэ. Лигт

оролцох багуудын тоглолт бүрийн хувцасны өнгийг ТЗБХ-ээс тодорхойлж эцэслэж зарлана.

- 5.1.4 Футзалын Лигт оролцох тоглогчид дүрмийн дагуу шаардлага хангасан өнгө, будаг гардаггүй заалны зориулалтын пүүзтэй байна. Мөн 5 дахь тоглогчийн өмсгөлийг зохих шаардлагын дагуу бэлдсэн байна. Өөр төрлийн пүүзтэй тохиолдолд тоглолтод оролцуулахгүй.
- 5.1.5 Хүндэтгэх шалтгаанаар тоглолтын хуваарьт өөрчлөлт орсон тохиолдолд 24 цагаас доошгүй хугацаанд тэмцээнд оролцож байгаа бүх багуудад мэдэгдсэн байна.
- 5.1.6 Тэмцээний зөвлөгөөнд багуудын төлөөлөл албан ёсны хувцастай байна.

Зургаа. Дүн гаргалт

- 6.1.1 Дараах байдлаар хэсгийн тоглолтын дүнг гаргана.

Хэрвээ 2 ба түүнээс дээш багууд ижил оноотой болсон тохиолдолд дараах шалгуураар тодруулна:

- a) Хоорондын тоглолтын дүнгээр,
- b) Хоорондын тоглолтын бөмбөгний зөрүүгээр,
- c) Хоорондын тоглолтын оруулсан бөмбөгний ихээр,
- d) Хүснэгтийн бүх тоглолтын бөмбөгний зөрүүгээр,
- e) Хүснэгтийн бүх тоглолтын оруулсан бөмбөгний ихээр,
- f) Багууд талбайд байвал торгуулийн цохилтоор,
- g) FIFA Fair Play оноо тодруулах зарчмаар
- h) Шодолтоор

Долоо. Лигийн үед мөрдөх зарчим

- 7.1.1 Лигт оролцож буй нийт баг тоглогчид, Хөл Бөмбөгийн спортыг эвсэг, нөхөрсөг, шударга, сонирхолтой байлгахын төлөө "AFC FAIR PLAY" зарчмуудыг Лигийн турш мөрдөх үүрэгтэй.
- 7.1.2 Тоглолт эхлэхийн өмнө болон төгсгөлд өрсөлдөгч хоёр баг "AFC FAIR PLAY" зарчмыг баримтлан тоглохоо илэрхийлж гар барих ба тоглолт дуусмагц тоглолтын үр дүнгээс үл хамааран хоёр багийн тоглогчид шүүгч нартай болон хөгжөөн дэмжигчдэд хүндэтгэл үзүүлнэ.

- 7.1.3 Оролцогч талууд тоглолтын талбай ба түүний орчин тойронд биеэ зөв боловсон авч явна.
- 7.1.4 Лиг зохион байгуулалтын талаарх санал гомдлыг тоглолт дуусаад 2 цагийн дотор ТЗБХ-т бичгээр өгнө.
- 7.1.5 Шүүгчийн шийдвэртэй холбогдолтой аливаа асуудлыг авч хэлэлцэхгүй.
- 7.1.6 МХБХ-ны бүх Лигийн үед гарсан сахилга бат, ёс зүйн холбогдолтой асуудлуудыг МХБХ-ны "Сахилгын дүрэм", "Ёс зүйн дүрэм"-ээр шийдвэрлэнэ.
- 7.1.7 Энэ зааварт тусгагдаагүй бусад асуудлыг ТЗБХ тухай бүрд нь шийдвэрлэнэ.

Найм. Шагнал урамшуулал, эрхийн хураамж

- 8.1.1 Лигийн эхний 3 байр эзэлсэн багт Эрхийн бичиг, Мөнгөн шагнал, Өргөмжлөл, медаль, түрүүлсэн багт "Аваргын Цом" олгоно.
- 8.1.2 1-р байр: аваргын цом, алтан медаль, өргөмжлөл, батламж , 5 сая төгрөг.
2-р байр: мөнгөн медаль, өргөмжлөл, батламж, 4 сая төгрөг.
3-р байр: хүрэл; медаль, өргөмжлөл, батламж, 3 сая төгрөг
4-р байр өргөмжлөл, батламж, 2,500,000 төгрөг
5-р байр өргөмжлөл, 2,000,000 төгрөг
6-р байр өргөмжлөл, 1,800,000 төгрөг
7-р байр өргөмжлөл, 1,600,000 төгрөг
8-р байр өргөмжлөл, 1,400,000 төгрөг
9-р байр өргөмжлөл, 1,200,000 төгрөг
10-р байр өргөмжлөл, 1,000,000 төгрөг
- 8.1.3 Лигийн аварга болон шилдэг үзүүлэлттэй баг нь Футзалын Дээд Лигт дэвшиж оролцно.
- 8.1.4 Лигийн шилдэг тоглогчдыг шалгаруулж, урамшуулна. Үүнд:
Шилдэг хаалгач: цом, батламж 200,000 мөнгөн шагнал.
Шилдэг тоглогч: цом, батламж 200,000 мөнгөн шагнал.
Шилдэг довтлогч: цом, батламж 200,000 мөнгөн шагнал.
Шилдэг шүүгч: цом, батламж 200,000 мөнгөн шагнал.

- 8.3.1 Монгол улсын Хувь хүний орлогын албан татварын хуулийн дагуу нийт шагналын сангийн 5% -ийг суутган тооцож, Татварын байгууллагад шилжүүлнэ.

Ес. Хэвлэл мэдээлэл

- 9.1.1 Лигийн үеэр ажиллах хэвлэл мэдээллийн хүмүүсийг албан ёсны зөвшөөрөлтэйгөөр тусгайлан зааж өгсөн газар ажиллахыг зөвшөөрнө. Багийн албан ёсны зурагчин тоглолтын үеэр зураг авах тохиолдолд, заавал МХБХ-ны Хэвлэл мэдээллийн ажилтантай холбогдож зохих зөвшөөрөл авч тусгай майктай орно.
- 9.1.2 МХБХ-ны Хэвлэл мэдээллийн ажилтны шаардлагын дагуу тухайн багийн албан хүн болон тоглогчид яриа өгөх үүрэгтэй.

Арав. Лигийн сахилга бат, ёс зүй

- 10.1 МХБХ-ны бүх тэмцээний үед гарсан сахилга ба ёс зүйн холбогдолтой асуудлуудыг МХБХ-ны "Сахилгын дүрэм", "Ёс зүйн дүрэм"-ээр шийдвэрлэнэ.
- 10.2 Тэмцээнд оролцох багууд МХБХ-ны "Сахилгын хорооны дүрэм", "Ёс зүйн хорооны дүрэм"- үүдтэй танилцаж, маш сайн ойлголтой байх үүрэгтэй.
- 10.3 Лигийн үеэр МХБХ-ны аливаа дүрэм, журамтай танилцаагүй гэсэн тайлбарыг хүлээн авахгүй.

Арван нэг. Бусад

- 11.1.1 МХБХ-ны ТЗБХ-ийн эрх мэдлээс давсан асуудлыг МХБХ-ны тухайн хороодод шилжүүлнэ.
- 11.2 Лигийн журам нь дараах хавсралтуудаас бүрдэнэ. Үүнд:
- ТЗБЖ Хавсралт 1 Лигийн мэдүүлэг
 - ТЗБЖ Хавсралт 2 Хувцасны өнгө
- Жич: Бүх хавсралтуудыг Лиг зохион байгуулах хэлтсээс файлаар дараах цахим хуудсаар хандаж авч болно.

МОНГОЛЫН ХӨЛБӨМБӨГИЙН ХОЛБОО

Логот



"....." КЛУБЫН МЭДҮҮЛЭГ.

ХУУДАС

1

ТЭМЦЭЭН


/ ТЭМЦЭЭНИЙ НЭР /

БАГИЙН АЛБАНЫ ХҮМҮҮСИЙН МЭДҮҮЛЭГ



ОВОГ
НЭР
АЛБАН ТУШААЛ
ИРГЭНШИЛ
УТАСНЫ ДУГААР
ЕМАЙЛ ХЯАГ
ДАСГАЛЖИУУЛАХ ЗЭРЭГЛЭЛ

Баттулга
Эрдэнэбат
Ахлагч Даасгалжуулагч
Монгол
99984421
meduiuleg.mff@gmail.com
AFC A



СҮУЛИЙН З САРД
АВАХУУЛСАН
ЦЭЭЖ ЗУРАГ

ОВОГ
НЭР
АЛБАН ТУШААЛ
ИРГЭНШИЛ
УТАСНЫ ДУГААР
ЕМАЙЛ ХЯАГ
ДАСГАЛЖИУУЛАХ ЗЭРЭГЛЭЛ


Page 1



СҮУЛИЙН З САРД
АВАХУУЛСАН
ЦЭЭЖ ЗУРАГ

ОВОГ
НЭР
АЛБАН ТУШААЛ
ИРГЭНШИЛ
УТАСНЫ ДУГААР
ЕМАЙЛ ХЯАГ
ДАСГАЛЖИУУЛАХ ЗЭРЭГЛЭЛ

Page 1



СҮУЛИЙН З САРД
АВАХУУЛСАН
ЦЭЭЖ ЗУРАГ

ОВОГ
НЭР
АЛБАН ТУШААЛ
ИРГЭНШИЛ
УТАСНЫ ДУГААР
ЕМАЙЛ ХЯАГ
ДАСГАЛЖИУУЛАХ ЗЭРЭГЛЭЛ

Page 1



СҮУЛИЙН З САРД
АВАХУУЛСАН
ЦЭЭЖ ЗУРАГ

ОВОГ
НЭР
АЛБАН ТУШААЛ
ИРГЭНШИЛ
УТАСНЫ ДУГААР
ЕМАЙЛ ХЯАГ
ДАСГАЛЖИУУЛАХ ЗЭРЭГЛЭЛ

Page 1

ХАВСРАЛТ 2


МОНГОЛЫН ХӨЛБӨМБӨГИЙН ХОЛБОО

Ш/х-259, Улаанбаатар-210646, Монголын Хөлбөмбөгийн Холбооны төв,
Хан-үүл дүүрэг, 15-р хороо, Улаанбаатар, Монгол Улс.
Утас 345964-17, Факс 345966



МОНГОЛЫН ХӨЛБӨМБӨГИЙН ХОЛБОО

"....." БАГИЙН ХУВЦАСНЫ МЭДҮҮЛЭГ



МОНГОЛЫН ХӨЛБӨМБӨГИЙН ХОЛБОО

